



Дундговь аймгийн
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 9/117

Мандалговь

Д.Анхбаярын нэхэмжлэлд шинжээчийн дүгнэлт гаргах тухай

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Дундговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 139/ШЗ2020/01675 дугаар шүүгчийн захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Д.Анхбаярын нэхэмжлэлтэй З.Мөнхдөлгөөнд холбогдох гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж тогтоох шинжээчийн дүгнэлт гаргах ажлыг 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 07 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулсугай.

2. Шинжээчийн дүгнэлт гаргахад шаардагдах 29370 (Хорин есөн мянга гурван зуун далан) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Хүүхдийн хөгжил, оролцоо, зуслангийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан (Б.Саранзаяа), гишүүдэд үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Хүүхдийн хөгжил, оролцоо, зуслангийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан (Б.Саранзаяа)-д даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ

9115

48115-157